



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№76 /520/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.12

Цаг үе, үйл явдал

## Г.САЙХАНБАЯР: ХӨХ ТЭНГЭР НЬ ЦЭЛМЭГ, ХӨӨРӨЛТ БУУЛТЫН ТОО НЬ ТЭНЦҮҮ БАЙГ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал болон түүний харьяа 303 дугаар ангид ажиллалаа.

Батлан хамгаалахын сайдыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалд хүрэлцэн ирэхэд Улаанбаатар цэргийн хүрээний хүндэт харуулууд хүндэтгэн угтаж,

Монголын хөх тэнгэрт анхлан "Ю-13" онгоц дүүлэн ниссэн. Уг өдрөөс эхлэн монгол залуус нисэх онгоц, техникийг гарамгай эзэмшиж улс орныхоо агаарын тээврийн салбарын хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмрийг оруулсан төдийгүй 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, Баруун хилийн тулгаралтад оролцож тусгаар улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалж ирсэн түүхтэй. Та бүхэн бол эдгээр зоригт баатруудын үйлсийг нэр төртэйгөөр залгамжлан

Д.Шатаррагчаа "Байлдааны туг"-ийг гурвантаа өргөхөд нийт бие бүрэлдэхүүн уухайлан хүндэтгэл үзүүлсэн юм. Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд тус ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, зэвсэглэл техник, тавиулангийн орчин, нөхцөлтэй танилцаж, ангийн удирдлагаас энэ онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, арга хэмжээ, түүнд тулгамдаж буй асуудлуудыг сонссон юм.

Зэвсэгт хүчний 303 дугаар

байгуулалт нь Монгол Улсын Зэвсэгт хүчинд өнгө нэмсэн онцлох ажлуудын нэг болох нь дамжиггүй. Урьд өмнө нь бид бүхэн ЗХУ-ын үеийн "Онгоц нисдэг тэрэгний засварын төв"-ийг ашиглаж үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Уг төв ашиглалтад орсноор нийт бие бүрэлдэхүүний ажиллах, сурч хөгжих орчин төгөлдөржиж, эрүүл мэнд бие бялдар, сэтгэлзүйн бэлтгэлжилт дээшлэх төдийгүй



Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат командлалын шинэ байрны тохижилт болон өдөр тутмын үйл ажиллагаа тулгамдаж буй асуудлуудаа уламжлав.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр агаарын цэргийн мэргэжлээр гадаадын цэргийн академи, их дээд сургуульд суралцагчдыг тасралтгүй бэлтгэх замаар боловсон хүчний нөхөн хангалтыг сайжруулах талаар онцгой ач холбогдол өгч ажиллахыг хурандаа Т.Ганбатад үүрэг болгосон юм. Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний 303 дугаар ангиллаж тус ангийн "Байлдааны туг"-ийг удирдлага, бие бүрэлдэхүүнд гардуулан өгсний зэрэгцээ "Онгоц нисдэг тэрэгний засварын төв"-ийн нээлтийн үйл ажиллагаанд оролцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд хэлсэн үгэндээ "Эл өдөр Та бүхэн сүлд хийморийн бэлгэдэл болсон Байлдааны тугаа гардан авлаа. Тэртээх 1925 оны 5 дугаар сарын 25-ны өдөр

үндсэн хуулиар хүлээсэн үүргээ тасралтгүй, найдвартай гүйцэтгэж, олон удаагийн онцгой, тусгай үүргийн нислэгээр эрдэнэт хүмүүний амь нас, эд хөрөнгийг цаг агаарын ердийн болон хүнд нөхцөлд авран хамгаалж, улс эх орон, удирдлагын дээд байгууллагын өгсөн үүрэг даалгаврыг нэр төртэйгөөр биелүүлж ирсэн бахархам хамт олон гэдгийг энд дурдахад таатай байна. Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын зүгээс Агаарын цэргийн командлал болон түүний харьяа ангиудын үүрэг гүйцэтгэлт бэлэн байдлыг дээшлүүлэх, зэвсэглэл техникийг шинэчлэх, хүний нөөцийг бэлтгэх, хангах асуудлуудыг бодлогын түвшинд шийдвэрлэн, дэмжлэг үзүүлэн ажиллах болно. Ингээд та бүхэндээ удахгүй болох Нисэх хүчний 98 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, хөх тэнгэр нь цэлмэг, хөөрөлт буултын тоо нь тэнцүү байхын ерөөлийг дэвшүүлэе" хэмээлээ.

Үүний дараагаар Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагч хурандаа



анги нь эл өдөр 60х60 харьцаатай 4800 м.кв талбай бүхий "Онгоц нисдэг тэрэгний засварын төв"-ийг албан ёсоор ашиглалтад хүлээн авсан юм. Уг төв нь дотроо нисдэг тэрэг хадгалах байр, зогсоол, нисгэгч, инженер, техникийн бүрэлдэхүүний ажлын байр, хичээл болон сургалтын танхим зэрэг орчин үеийн стандарт нийцсэн бүхий л төрлийн албан тасалгаа, техник хэрэгсэлтэй юм. Энэ талаар Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагч хурандаа Д.Шатаррагчаа хэлэхдээ "Энэхүү бүтээн

нисгэгч, инженер, техникийн бүрэлдэхүүний бэлэн байдал үлэмж хэмжээгээр нэмэгдэх онцгой ач холбогдолтой юм. Энэ завшааныг ашиглаад уг төвийг барьж байгуулах санаачилгыг гаргаж БХЯ, ЗХЖШ-аас бодлогын түвшинд дэмжиж өгсөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон бусад албаны хүмүүст Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүний өмнөөс талархал илэрхийлье" гэлээ.

Дэслэгч Ө.НАСАНТОГТОХ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	6


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	28

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,465	3,470
EUR	3,830	3,848
CNY	503	504.50
RUB	43.20	43.70
JPY	25.70	25.93
KRW	2.64	2.66

### ЗУРХАЙ



2023.05.12 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 22

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР**  
**НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдоно  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
05.18-20.19

**Барилдлага:**

Идэр

**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**

САНСАР

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,944,899

Эдгэрсэн

Нийт: 660,364,054

Нас барсан

Нийт: 6,872,514

Цахим шууданд

ТҮҮХЭН СУРГАМЖ МАРТАГДАХ УЧИРГҮЙ



талбарт эрэн хайх ажиллагаа явуулж, сураггүй болсон монгол орос дайчдыг эрэн сурвалжлах, ёс төртэй нутаглуулах зэрэг ажлыг зохион байгуулсан талаар Улаан Үд дэх "Россия" телевизийн сэтгүүлч Жаров баримтат кино үзүүлж тайлбар өгсөн юм.

"Монгол Улс Дэлхийн 2 дугаар дайнд" номын орчуулагч, түүхч, бэлтгэл дэд хурандаа С.Өлзийдүүрэн товч мэдээлэл хийсэн. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Инженерийн цэргийн холбооны тэргүүн, чөлөөнд байгаа дэд хурандаа Ё.Ариунболд хэлсэн үгэндээ "Намайг сонсогч байхад Калининградын Цэргийн инженерийн дээд сургуульд дайнд оролцсон ахмад багш нар хичээл зааж, туршлага өвлүүлдэг байж билээ. Бид тийм эх орончдоор хичээл ном заалгасан хүмүүс" хэмээн ярьсан. Мөн хурандаа Цыремпилов Цырен дайнд мордсон өвөг, дээдсийнхээ тухай, тэдний бахархам түүхийг сонсож өсч хүмүүжсэн талаар дурсамжаа хуваалцав.

Хурлын үеэр Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, бэлтгэл дэд хурандаа Д.Лувсанням, хошууч Р.Батболд нар уран бүтээлээсээ сонирхуулж "Три танкиста" зэрэг дууг баян хуур хөгжимтэй дуулж, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ирсэн ахлах дэслэгч Саяна эх орны сэдэвт шүлэг уншиж сонирхууллаа.

Хоёр орны эрдэмтэд, судлаачид бэлэг дурсгалын зүйл солилцож ирэх жилийн 5 дугаар сарын 9-ний баяраар бага хурлын ажиллагааг үргэлжлүүлэн явуулах талаар талууд харилцан тохиролцсоноор дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг амжилттай өндөрлөв.

Бэлтгэл хурандаа Г.НЯМДОРЖ

"1941-1945 оны Аугаа Эх орны дайны сургамж, ач холбогдол" сэдэвт Олон улсын дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг "Амар" зочид буудлын хурлын танхимд боллоо. Ярилцлага, хэлэлцүүлгийг "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" ТББ, Ахмад дайчдын "Улаан одхон" сонины зөвлөлөөс ОХУ-ын Буриад улсын Хүүхэд залуучуудын эх оронч хүмүүжлийн "Юнармия" олон нийтийн байгууллагатай хамтран зохион байгуулсан юм.

Нэгдсэн эвлэлийн тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа нээж хэлсэн үгэндээ "Эх орны дайны ялалтад Монголын ард түмний оруулсан хувь нэмэр багагүй. Тийм учраас хүн төрөлхтнийг фашизмын боолчлолоос авран хамгаалсан энэ дайны ялалт бидэнд үнэ цэнтэй хэвээр байх болно" гэв.

"Юнармия" байгууллагын тэргүүн, чөлөөнд байгаа дэд хурандаа Владимир Ефремов "Энэ удаагийн 2 дахь бага хурлын үеэр хоёр орны

ард түмний дайны жилүүдийн хамтын ажиллагааг хөндөн ярьж түүх судалгааны шинэ баримтуудыг нийтийн хүртээл болгоно гэдэгт итгэл дүүрэн байгаа" гэж яриу.

"Орос, Монголын хамтын ажиллагаа Эх орны дайны жилүүдэд" гэсэн илтгэлийг хурандаа Цыремпилов Цырен тавьж хэлэлцүүлсэн. Москвагийн дэргэд болсон тулалдааны үеэр орос дайчид монголоос ирүүлсэн хагас нэхий дээлийг өмсөж, монгол морьд фронтын хүнд бэрх замыг туулж Берлин хүрсэн тухай сонирхолтой сэдвийг хөндлөө.

Дараа нь доктор, дэд профессор, бэлтгэл дэд хурандаа Л.Баяр "Монголын ард түмний тусламж дайны жилүүдэд (тоон үзүүлэлтээр)" илтгэлийг хэлэлцүүлэв. Бэлэглэлийн цуваануудад хүнд хэрэгцээтэй бүхэн багтсан бөгөөд тулалдаан түр амсхийхэд дайчдын татах тамхи хүртэл байсан тухай тоо баримт дурдан ярьсан.

Мөн Халхын голд дайны

“ХҮНДЭТГЭН ДУУРСАХ АЛДАР” ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



хөгжимчин МУСТА Б.Мөнхцэцэг, дуучин МУСТА Ж.Цэрэнханд, ажилтан МУСТА С.Алтанчимэг нарын хөдөлмөр, бүтээлийг алдаршуулав.

Эл өдөрлөгт Соёлын яамны стратеги төлөвлөлтийн газрын дарга З.Баянзул, УГЗ Ч.Гансүх нарын хүндэт зочид болон ЦДБЭЧ-ын нийт бие бүрэлдэхүүн, Ахмадын хорооны тэргүүлэгчид, "Хан эгшиг" НҮТББ, "Жаран хар арван цагаан" НҮТББ, Монгол цэргийн бүжгийн "Гэрэгэ" холбооны удирдлагууд, үе үеийн ахмадууд оролцсон юм.

Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, чуулгын Ахмадын хороо хамтран "Хүндэтгэн дуурсах алдар" өдөрлөгийг зохион байгууллаа.

"Хүндэтгэн дуурсах алдар" өдөрлөгөөр ЦДБЭЧ-аас тэтгэвэр чөлөөнд гарсан ахмад бүжигчин МУСТА Х.Дамба,



ЗЕНИТЧДИЙН ТАЛБАЙД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫНХАН МОД ТАРЬЖ БАЙНА



"Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Мод үржүүлгийн төвд өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны судалгаа шинжилгээний төв, Цаг уур, орчны шинжилгээний газар, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Ойн газрын зарим алба хаагч мод тарьж байна.

Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Мод үржүүлгийн төв нь нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо Түргэний гол дагуу байгуулагдсан бөгөөд нийтдээ 8 га газрыг ойн төгөл болгохоор ажиллаж байгаа юм. Ингэхдээ тус төв нь үрээр буйлс, хайлаас, шар хуайс, 6 нэр төрлийн цэцэг, тайраадсаар цагаан, хүрэн бургас, улиас зэргийг үрслүүлэн тариалж, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад нийлүүлэхийн зэрэгцээ төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд талбайд нь мод тарихад нь дэмжлэг үзүүлж байгаа нь энэ юм.

Нийгмийн хариуцлагын

хүрээнд байгаль орчноо хамгаалан мод тарьж байгаа байгууллагын төлөөлөгчдөд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал Ойн газартай хамтран мэргэжлийн хүмүүсийн заавар, зөвлөмжөөр энэхүү төгөлийг бүтээж байгааг онцлоод "Хүн бүр байгаль хамгаалагч" хэмээн тодотгож байсан юм.

"Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан маргааш буюу ням гарагт Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Авлигатай тэмцэх газар, Туул голын сав газрын захиргаа, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Оюуны өмчийн газар зэрэг 10 гаруй төрийн яам, агентлагийн алба хаагчид тус ангийн Мод үржүүлгийн төвд хуваарийн мод тарина.

Ташрамд онцлоход энэ өдрүүдэд Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангийн 70 гаруй хугацаат цэргийн алба хаагч байгаль орчноо хамгаалах үйлсэд манлайлан оролцож, тариалалтын үеийн усалгаа, арчилгаа, бусад бэлтгэл ажлыг хангаж байна.

ДОРНОД АЙМАГТ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ”, “ШОНХОР” ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТ БОЛЛОО



Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, түүх, соёл уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэлзүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах халамж залгааг бэлтгэх зорилгоор

Дорнод аймагт цэрэг-спортын "Дөл-2023", "Шонхор-2023" тэмцээнийг зохион байгуулж байна.

Дорнод аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор тэмцээний нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга,

хурандаа О.Ганзориг, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Э.Эрдэнэбилэг болон төрийн цэргийн байгууллагын дарга нар, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, бэлтгэл, чөлөөнд байгаа хурандаа нар оролцлоо. Энэ үеэр Зэвсэгт хүчний 327 дугаар анги болон аймгийн Онцгой байдлын газраас үйл ажиллагаандаа ашиглаж буй техник хэрэгслийн үзэсгэлэнг дэлгэсэн юм.

Тэмцээнд аймаг болон сумдын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 17 багийн 200 гаруй сурагчид хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөх юм.

Энэ жил "Шонхор-2023" тэмцээнийг анх удаа зохион байгуулж буйгаараа онцлог юм.

Хошууч П.ЧУХАЛХҮҮ



НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГ ДҮҮЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийг "Бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүд" болгон зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчний 336 дугаар ангид 2022-2023 оны ХЦАХ-дын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг байгуулж хайлаас 1000 ширхэг, заг 600 ширхэг, улаан сухай 500 ширхэг, жигд 100 ширхэг, агч 60 ширхэг, буйлс 50 ширхэг, улиас 30 ширхэг, чацаргана 10 ширхэг, нийт 8 төрлийн 2350 ширхэг мод бут суулгалаа.

Ахлах дэслэгч Ө.БААСАН-ОЧИР

